

**КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ,
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТАЛААР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагын Ерөнхий бага хурлын 2001 оны 31 дүгээр чуулганаар баталсан Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон баталснаар усан доорх соёлын өвийг хамгаалах тогтолцоо бүрдэх, соёлын өвийн зүйлсийг дээрэмдэх, хууль бусаар зөөвөрлөх, арилжааны зорилгоор ашиглахаас хамгаалах, усан доорх археологийн чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн техникийн туслалцаа авах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг чухал ач холбогдолтой.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир дээрх конвенц нь далайд гарцгүй улс орны хувьд чухал ач холбогдолтой талаар дурдаж, Монгол Улсад усан доорх археологийн дурсгалт газар, олдворууд байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар конвенцод нэгдэн орсноор дотоодын усан доорх соёлын өвийг хамгаалах төдийгүй соёлын өв хаана байгаагаас үл хамааран өөрийн хил хязгаараас гадуурх ашиг сонирхлыг хамгаалахад оролцох эрхтэй болох талаар үг хэлсэн болно.


Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 68.8 хувийн саналаар дэмжиж, эцэслэн батлуулахаар чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх, хэлэлцүүлэхийг шийдвэрлэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, уг хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

~~Төрийн ордон,~~
Улаанбаатар
хот

КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага /ЮНЕСКО/-ын Ерөнхий бага хурлын 2001 оны 31 дүгээр чуулганаар баталсан “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг